

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 3 ДУГААР АНГИЙН АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ
АГУУЛГЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

А ХУВИЛБАР ЗА АНГИЙН СУРАГЧ

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ 18 ОНОО

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

САНАМЖ: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

Согоон цэцэг

Модон дотор ургадаг ягаан цэцэг хүн, мал ямарч амьтны цусыг тогтооход хэрэглэдэг эмийн ургамал байжээ. Анх удаа нээгдсэн эмийн ургамлыг “Согоон цэцэг” гэж нэрлэсэн нь гайхалтай. Дондогийг аавтайгаа ойд явж байтал модны чөлөөнд хоёр чоно согоо барьж байгаад хүний чимээгээр зугтаажээ. Согооны хүзүү, хонго их шархадсан харагдана. Шархтай согоо ойн цоорхойд очиж ягаан цэцэг түүж идэв. Аав нь явахдаа хоёр мануухай босгож, согоог чононоос хамгаалжээ. Дондогийг “Согоогоо үзээд ир” гэж аав нь өдөр алгасалгүй явуулна. Арваад хоногийн дараа шархтай согоо эдгэрээд ойн гүнд явчихжээ.

1.1 Дондог ойд хэнтэй явж байсан бэ? \ 1оноо \

а. ээжтэйгээ б. аавтайгаа в. ганцаараа г. найзтайгаа

1.2 “Согоо “ гэдэг үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг сонгоорой. \ 1 оноо \

а. эмийн ургамал б. зэрлэг ургамал в. цэцэгт ургамал г. эм буга

1.3 Дан ялгах эгшигтэй үг орсон хэсгийг олоорой. \ 1 оноо \

а. сан, чоно, буга б. хог, цэцэг, ургамал в. хонго, буга, харагдана

1.4 Дараах үгтэй ойролцоо утгатай үг 2-ыг бичээрэй. \ 1 оноо \

бүгд -

ХОЁР: БИЧИХ ДААЛГАВАР

2.1 Дараах үгсээр утга ялгасан өгүүлбэр зохиож бичээрэй. \ 2 оноо \

буга-


буг-

2.2 Аав хүү хоёрт зориулж талархлын захидал бичээрэй. Захидлыг бүтцийн дагуу бичээрэй.
/3 оноо/
.....
.

МАТЕМАТИК ХИЧЭЭЛ

НЭГ: СОНГОХ ДААЛГАВАР Сонгох даалгавар бүр 1 оноотой.


1.1 Цэгийн оронд тохирох тоог олоорой. \ 1 оноо \



1.2 Нэг нь нөгөөгөөсөө нэг зуугаар бага байх хос тоог олоорой. \ 1 оноо \


- а. 497 ба 507 б. 328 ба 418 в. 6100 ба 5100 г. 2783 ба 2683

1.3 А, Б дүрсүүдийн нэрийг зөв бичсэн хэсгийг сонгоорой. \ 1 оноо \




- а. Б дугуй, А тойрог б. А дугуй, Б тойрог в. хоёулаа тойрог г. хоёулаа дугуй

1.4 Аль диаграммд нийт 75 жимс дүрслэгдээгүй байна вэ? \ 1 оноо \




ЗАДГАЙ ДААЛГАВАР

1.1 1 см талтай квадрат мөн 1см талтай кубын дэлгээсийг үргэлжлүүлэн гүйцээж зураарай. \ 2 оноо \



1.2 Хүснэгтэд өгсөн өгөгдлийг баганан диаграммаар дүрслээрэй. \ 3 оноо \

	Хүүхдүүдийн нэр	Үсэрсэн тоо (дээс)
1	Дорж	8
2	Сувд	22
3	Амар	10
4	Болд	8
5	Туяа	15
6	Бат	20



а. Сувд Батаас хэдээр олон үсэрсэн бэ? _____

б. Бүх хүүхэд нийлээд хэд үсэрсэн бэ? _____

ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

	АТБХ	Үнэлгээний зорилт	Зөв хариу	оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
Монгол хэл	Унших	мэдлэг ойлголт	Б	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
		мэдлэг ойлголт	Г	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
		чадвар	В	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
	Хэл зүй	чадвар	бүгд- нийт, бүх, цөм	1	Хоёр үг олсон бол 1 оноо, нэгийг бичсэн бол 0,5 оноо, огт бичээгүй бол 0 оноо
ХОЁР. БИЧИХ ДААЛГАВАР					
Монгол хэл	Бичих	чадвар	Утга ялгаж, өгүүлбэр зохиосон бол	2	Үгийн утгыг зөв гаргаж өгүүлбэр зохиосон бол бол 2 оноо, дутуу буруу бол 1 оноо, бичээгүй бол 0 оноо
		хэрэглээ	Захидлын бүтцийн дагуу бичих	3	Талархлын захидлыг бүтцийн дагуу бүрэн гаргаж бичсэн бол 3 оноо, аль нэг бүтцийг орхигдуулсан бол 2 оноо, бүтцийн дагуу бичээгүй ч санаагаа гаргаж бичсэн бол 1 оноо, огт бичээгүй бол 0 оноо
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
Математик	Тоо тоолол	мэдлэг ойлголт	20 гэж бичнэ.	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу бичсэн буюу огт бичээгүй бол 0 оноо
	Хэмжиг дэхүүн	чадвар	Г. 2783 ба 2683	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
	Геометр	мэдлэг ойлголт	Б. А дугуй Б тойрог	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
	Өгөгдөл тэй ажиллах	мэдлэг ойлголт	Г. 	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР					
Математик	Хэмжиг дэхүүн	хэрэглээ	Квадрат, куб дэлгээс	2	Квадрат, куб зөв зурсан бол 2 оноо, нэгийг зураагүй бол 1 оноо, огт бичээгүй бол 0 оноо
	Өгөгдөл тэй ажиллах	чадвар	Диаграммд дүрслэх, Сувд Батаас 2оор олон үсэрсэн. Бүгд 83 үсэрсэн.	3	Багнан диаграммд зөв дүрсэлсэн бол 1 оноо, буруу дутуу дүрсэлсэн бол 0 оноо а. хэдээр олныг зөв олсон бол 1 оноо, олоогүй буюу буруу олсон бол 0 оноо б. бүх тоог зөв олсон бол 1 оноо буруу дутуу бичсэн бол 0 оноо
				18	

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 3 ДУГААР АНГИЙН АНГИ ДЭВШИХ НЭГДМЭЛ
АГУУЛГЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ**

Б ХУВИЛБАР За ангийн сурагч

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ 18 ОНОО

НЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: 1. Эхийг анхааралтай уншиж ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй. Сонгох даалгавар бүр 1 оноотой.

Тоншуул яагаад мод тоншдог вэ?

Тоншуул өдөр бүхэн яарч мод тонших нь хүнс тэжээлээ хайж байгаа хэрэг. Эхлээд модны их биеийг тоншиход “тон тон” гэсэн дуу гарна. Дууны их багын ялгаагаар модны холтсон доор хорхойны нүх байгаа эсэхийг андахгүй таньдаг байна. Өт хорхойг мэдэнгүүт урт хэлээрээ гүн нүхэнд байгаа хорхойг авна. Тоншуул модон доторх хортон шавжийг устгадаг учраас түүнийг “Ойн эмч” хэмээн нэрлэдэг билээ.

1.1 Зөв хариултыг сонгоорой. \ 1 оноо \

Тоншуул хүнс тэжээлээ хаанаас хайж олдог вэ?

а. модноос б. газраас в. ойгоос г. цэцэгнээс

1.2 Тоншуул модонд хорхойны нүх байгааг яаж мэддэг вэ? \ 1 оноо \

а. тон тон гэсэн дуу гарахад в. дууны их багын ялгаагаар
б. модны орой дээр суугаад г. мод тоншиж

1.3 Доорх амьтдын хийдэг үйлийг зөв холбоорой. \ 1 оноо \

Тоншуул модыг иддэг.
Өт хорхой өт хорхойг иддэг.

1.4 Дараах үгсэд тохирох асуултуудыг зөв харгалзуулсан хэсгийг сонгоорой. \ 1 оноо \

1. мод	а. хаана?	а. 1б, 2в, 3г, 4а
2. тонших	б. юу?	б. 1г, 2а, 3в, 4б
3. хорхойг	в. яах?	в. 1а, 2г, 3в, 4б
4. ойд	г. юуг?	г. 1в, 2б, 3а, 4г

ХОЁР: БИЧИХ ДААЛГАВАР

2.1 Дараах үгсээр утга ялгасан өгүүлбэр зохиож бичээрэй. \ 2 оноо \

харх -
харах-.....

2.2 Тоншуулд зориулж талархлын захидал бичээрэй. Захидлыг бүтцийн дагуу бичих 3 оноо

.....
.....
.....

ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ СХЕМ

АТБХ		Үнэлгээний зорилт	Зөв хариу	оноо	Онооны тайлбар
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
Монгол хэл	Унших	мэдлэг ойлголт	А	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
		мэдлэг ойлголт	В	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
		чадвар	Тоншуул өт хорхойг Өт хорхой модыг	1	зөв холбосон бол 1 оноо, буруу холбосон буюу огт холбоогүй бол 0 оноо
	Хэл зүй	чадвар	А а.1б,2в,3г,4а	1	Зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу сонгоогүй бол 0 оноо
ХОЁР. БИЧИХ ДААЛГАВАР					
Монгол хэл	Бичих	чадвар	Утга ялгаж, өгүүлбэр зохиосон бол	2	Үгийн утгыг зөв гаргаж өгүүлбэр зохиосон бол бол 2 оноо, дутуу буруу бол 1 оноо, бичээгүй бол 0 оноо
		хэрэглээ	Захидлын бүтцийн дагуу бичих	3	Талархлын захидлыг бүтцийн дагуу бүрэн гаргаж бичсэн бол 3 оноо, аль нэг бүтцийг орхигдуулсан бол 2 оноо, бүтцийн дагуу бичээгүй ч санаагаа гаргаж бичсэн бол 1 оноо, огт бичээгүй бол 0 оноо
НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР					
Математик	Тоо тоолол	мэдлэг ойлголт	Б	1	Зөв сонгосон бол 1 оноо, буруу бичсэн буюу огт бичээгүй бол 0 оноо
	Хэмжиг дэхүүн	чадвар	В	1	Зөв сонгосон бол 1 оноо, буруу бичсэн буюу огт бичээгүй бол 0 оноо
	Геометр	мэдлэг ойлголт	Б	1	зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
	Өгөгдөл тэй ажиллах	мэдлэг ойлголт	В	1	Зөв сонгосон бол 1 оноо, буруу сонгосон буюу огт сонгоогүй бол 0 оноо
ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР					
Математик	Хэмжиг дэхүүн	хэрэглээ	3л, 2л, 5л, 1л	2	Бүгдийг зөв бичсэн бол 2 оноо, Нэгийг бичээгүй бол 1.5оноо, хоёрыг бичээгүй бол 1оноо, гурвыг бичээгүй бол 0.5 оноо, Огт бичээгүй бол 0оноо
	Өгөгдөл тэй ажиллах	чадвар	Хавар21 Зун 12 Намар 25 Өвөл 10 Хүснэгтэд дүрслэх, хавар, намар	3	а. улирал тус бүр 0.25 оноо, зөв олсон бол 1 оноо б.Баганан диаграмм зөв дүрслэл тус бүр 0.25 оноо, зөв бол 1 оноо, сондгой тоотой улирлыг зөв олсон бол 1 оноо, олоогүй бол 0 оноо
				18	

ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН: 3 –Р АНГИЙН БАГШ З.ДАРЙЙМАА

